

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/3/СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
-------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ХХҮЕГ</i>	<i>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар</i>
<i>ХХҮГ</i>	<i>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар</i>
<i>ХБИ</i>	<i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</i>
<i>ХЭДС</i>	<i>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан</i>
<i>ХХК</i>	<i>Хариуцлагатай хувьцаат компани</i>
<i>СХС</i>	<i>Сум хөгжүүлэх сан</i>
<i>ААНБ</i>	<i>Аж ахуйн нэгж байгууллага</i>
<i>БҮТЭЗ</i>	<i>Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл</i>
<i>НХА</i>	<i>Нийтийг хамарсан ажил</i>

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	8
3.1. Ерөнхий зүйл .....	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	9
3.4. Материаллаг байдал .....	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.9. Аудитын илрүүлэлт .....	12
Залруулсан алдаа .....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж .....	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	12
4. Менежментийн захидал .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	15

## 1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА  
Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

2021-02-11 № 2/45  
тандай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

021020349

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

ТАТВАРЫН ХЭЛТСИЙН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,354,510,301</u></b>	<b><u>2,654,035,820</u></b>
33	<b>АВЛАГА</b>	2,354,510,301	2,652,013,320
33300	Татаас, санхүүжилтийн авлага	32,587,031	1,352,000
336	<b>Зээлийн авлага</b>	2,321,923,270	2,650,661,320
3361	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	2,321,923,270	2,650,661,320
33612	Хувь хүмүүст олгосон зээл	2,321,923,270	2,650,661,320
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	-	2,022,500
354	<b>Хангамжийн материал</b>	-	2,022,500
35440	Түлш, шатах тослох материал		730,000
35470	Бусад хангамжийн материал		1,292,500
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,354,510,301</u></b>	<b><u>2,654,035,820</u></b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>448,673,950</u></b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	448,673,950
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	448,673,950
4121	<b>Төгрөг</b>	-	448,673,950
41212	Хувь хүмүүст олгосон зээл		448,673,950
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,354,510,301</u></b>	<b><u>2,205,361,870</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,354,510,301	2,205,361,870
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,354,510,301	2,205,361,870
51210	Өмнөх үеийн үр дүн	2,354,510,301	2,354,510,301
51220	Тайлант үеийн үр дүн		(149,148,431)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,354,510,301</u></b>	<b><u>2,654,035,820</u></b>

### 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,969,592,000</b>	<b>1,181,171,230</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,592,000</b>	<b>33,956,730</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,592,000	33,956,730
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,592,000	33,956,730
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,592,000	33,956,730
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,964,000,000</b>	<b>1,147,214,500</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,964,000,000	1,147,214,500
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,964,000,000	1,102,200,000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		45,014,500
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,231,684,059</b>	<b>1,330,319,661</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,231,684,059</b>	<b>1,330,319,661</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,500,000	28,434,437

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000	3,663,437
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000	3,663,437
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	24,771,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,665,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		14,106,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,229,184,059	1,301,885,224
2132	Бусад урсгал шилжүүлэг	753,000,397	900,816,481
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	753,000,397	900,816,481
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,592,000	32,804,730
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,592,000	32,804,730
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	19,202,063
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		19,202,063
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	470,591,662	349,061,950
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	470,591,662	349,061,950
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>737,907,941</u>	<u>(149,148,431)</u>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,453,271,090</u>	<u>1,530,433,180</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	487,081,090	383,218,680
120	Нийтлэг татварын бус орлого	487,081,090	383,218,680
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	487,081,090	383,218,680
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	481,489,090	349,261,950
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,592,000	33,956,730
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,966,190,000	1,147,214,500
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,966,190,000	1,147,214,500
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,964,000,000	1,102,200,000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,190,000	45,014,500
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,453,271,090</u>	<u>1,530,433,180</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,453,271,090	1,530,433,180
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,500,000	29,164,437
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000	3,663,437
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000	3,663,437
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	25,501,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,395,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		14,106,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,450,771,090	1,501,268,743
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,942,000,397	1,100,200,000
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,942,000,397	1,100,200,000
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,592,000	33,956,730

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,592,000	33,956,730
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	21,689,603	18,050,063
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,689,603	18,050,063
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	481,489,090	349,061,950
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	481,489,090	349,061,950

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,354,510,301	2,354,510,301
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,354,510,301	2,354,510,301
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,354,510,301	2,354,510,301
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,354,510,301	2,354,510,301
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,354,510,301	2,354,510,301
D08	Тайлант үеийн үр дүн	(149,148,431)	(149,148,431)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,205,361,870	2,205,361,870

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,966,688,000	1,944,500,397	1,611,473,500	744,893,680
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,966,688,000	1,944,500,397	1,611,473,500	744,893,680
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,000,000	2,500,000	-	29,164,437
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,000,000	2,500,000	-	3,663,437
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000	2,500,000		3,663,437
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	-	25,501,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал				11,395,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх				14,106,000
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,962,688,000	1,942,000,397	1,611,473,500	715,729,243
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,962,688,000	1,942,000,397	1,611,473,500	715,729,243
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,962,688,000	1,942,000,397	1,611,473,500	715,729,243
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,966,688,000	1,944,500,397	1,613,473,500	744,893,680
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,964,688,000	1,457,419,307	1,611,473,500	351,000,000
131001	Улсын төсвөөс санхүүжих				
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,964,688,000	1,457,419,307	1,611,473,500	351,000,000

120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	2,000,000	487,081,090	2,000,000	393,893,680
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		481,489,090		349,061,950
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000	5,592,000	2,000,000	32,804,730
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих				
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих				12,027,000

## **2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>784,187,500</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>784,187,500</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>15,137,437</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,137,437</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,137,437
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>769,050,063</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>769,050,063</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	751,200,000
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>17,850,063</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	17,850,063
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>784,187,500</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>784,187,500</b>
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	32,987,500
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	751,200,000

## **3. АУДИТЫН ТАЙЛАН**

### **3.1. Ерөнхий зүйл**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Л.Билэгдэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, сангийн хөрөнгийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, зарцуулалт, үндсэн хөрөнгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 05-наас 2021 оны 02 дугаар сарын 10-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “хөдөлмөр, эрхлэлтийг дэмжин хөгжүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай хүргэх,

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, улмаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах” гэсэн зорилго, зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах*
- *Ажилд зуучлах*
- *Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах*
- *Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах, иргэнийг дэмжих*
- *Нийтийг хамарсан ажил зохион байгуулах*
- *Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих*
- *Ажлын байр нэмэгдүүлэх санхүүгийн дэмжлэг*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 1 тоот тогтоолын 5 дугаар хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”- т өөрчлөлт*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хяналт мониторингийн газраас сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт хийгдээгүй, хяналт үнэлгээ хийх талаар нэгдсэн удирдамж, чиглэлийг албан тоотоор ирүүлснээр байгууллагын захиргаа хяналтын хэлтсээс хяналтуудыг тухай бүр хэрэгжүүлэн, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 908351.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 9083.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 1181171.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 11811.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 299525.5 мянган төгрөгөөр буюу 13 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр, төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	2,354,510.3	2,652,013.3	297,503.0
Бараа материал		2,022.5	2,022.5
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,354,510.3	2,654,035.8	299,525.5
Богино хугацаат өр төлбөр		448,673.9	448,673.9
Цэвэр хөрөнгө, өмч	2,354,510.3	2,205,361.9	(149,148.4)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	2,354,510.3	2,654,035.8	299,525.5

Авлага дансны үлдэгдэл 2652013.3 мянган төгрөг болж 297503.0 мянган төгрөгөөр өссөн нь төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд 2020 онд 735980.0 мянган төгрөгийн зээл олгогдож нэмэгдсэн байна.

Нийт авлагын 471182.4 мянган төгрөг буюу 17.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна. Хугацаа хэтэрсэн зээлүүдийг шүүхийн эвлэрүүлэн зуучлахад, шийдвэр гүйцэтгэх газарт тус тус шилжүүлсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 2022.5 мянган төгрөг болж 2022.5 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой БҮТЭЗ, шатах тослох материал худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 448673.9 мянган төгрөг болж 448673.9 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд батлагдсан сангийн хөрөнгийн эх үүсвэрийг 7 сараас бүрэн олгоогүйгээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 448673.9 мянган төгрөгийн өр төлбөрөөс Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрт 8600.0, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 296458.0, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт 60331.0, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 5900.0, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөр 28488.0, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр 10600.0, нийтлэг үйлчилгээний хөтөлбөрт 12090.0, бусад үйл ажиллагааны зардалд 26206.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2204631.9 мянган төгрөг болж 149878.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 149878.4 мянган төгрөгийн алдагдалтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 788420.8 мянган төгрөгөөр буюу 40 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвийн санхүүжилт 861800.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн, туслах үйл ажиллагааны орлого 28364.7 мянган төгрөгөөр илүү бүрдүүлсэн, дэлхийн банкнаас 45014.5 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг хүлээн авсан байна.

Нийт зардал өмнөх оноос 98635.6 мянган төгрөгөөр буюу 8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг бараа ажил үйлчилгээний зардал 25934.4, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал 147816.1, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн зардал 27212.7, улсын төсөвт төвлөрүүлэлт 19202.1 мянган төгрөгөөр тус тус өссөн, зээлийн эргэн төлөлт 121529.7 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1974600.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1974600.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1397100.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 4 удаа өөрчлөлт оруулж ХХҮЕГ-ын 2020 оны 12 дугаар сарын А/186 тоот тушаалаар 1611473.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 351000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 33956.7, зээлийн эргэн төлөлтөөс 349261.9, дэлхийн банкнаас туршилтын хөтөлбөрийн зардалд 12027.0 мянган төгрөг, нийт 746245.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 744893.6 мянган төгрөгийг зарцуулж 1325.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 744893.6 мянган төгрөг буюу 53.8 хувьтай байгаа нь улсын төсвөөс олгох 751200.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар олгож зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 6 сараас хойш олгох санхүүжилт 751200.0, дэлхийн банкны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрт 32987.5 мянган төгрөг нийт 784187.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ 9390.0, ажилд зуучлах үйлчилгээ 1833.7, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр 11280.0, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 300424.8, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр 36952.0, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр 68312.0, малчдыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 245326.3, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр 52280.0, бусад арга хэмжээнд 25401.2, дэлхийн банкны сургалтад 15137.4 мянган төгрөг нийт 766337.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 17850.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлогын 5 ажил гүйлгээ, зарлагын 12 ажил гүйлгээний мэдээллийг оруулаагүй, батлагдсан төсөвт орсон мэдээлэл, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт хэтрэлтийн шалтгааныг бүрэн байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллээс эрсдэлтэй гэж үзсэн гүйлгээг хянахад 2020 оны 3 дугаар сард ХЭДС-ийн 350000.0 мянган төгрөгийн санхүүжилт, 10 дугаар сард зээлийн эргэн төлөлтийн 20000.0, Мо Эн Ко ХХК-аас ХБИ ажиллуулаагүй төлбөрт 7318.5 мянган төгрөгийн орлогын ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 45490.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	45,490.0	3	45,490.0	1	-	75
Нийт дүн	4	45,490.0	3	45,490.0	1	-	

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 70925.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1460.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 69465.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын үлдэгдлийг 730.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
2. Тайлант оны үр дүнг 730.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасантай холбоотой залруулгыг аудитын явцад хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж 1460.0 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 69465.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Жаргалант сумын хэмжээнд нийтийг хамарсан ажилд иргэдийг хамруулан ажиллуулахдаа аймгийн ХХҮГ-аас ирүүлсэн жагсаалтад байгаа хүмүүс дээр нэмж сумын 12 багын ажилгүй иргэдийг авч ажиллуулахдаа Хот тохижилтийн газрын нягтлан бодогч, нярав

нарын хамаарал бүхий хүмүүс ажилласан, ажиллаагүй талаар иргэдийн дунд бухимдал үүсгэсэн, мөн хувийн хэвшилд ажилладаг хүмүүс ажиллуулж цалин олгодог зэрэг анхаарал татахуйц асуудалтай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2020 онд зохион байгуулагдсан сургалтуудад бал, дэвтэр олгох, 1.2 дугаар хоол олгох зэрэгт сангийн хөрөнгийг зарцуулсан нь хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, оны эцэст 448673.9 мянган төгрөгийн өр төлбөр тусгасныг тулган баталгаажуулаагүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1.Зээлдэгчийн мэдээлэлтэй холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Аудитын хүрээнд түүвэрлэн хянахад төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаа зээлдэгчдийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулаагүйгээс сумдын СХСан болон бусад хэлбэрээр зээлийг давхардуулан авч зээлийн эргэн төлөлт удааширч, зээлдэгчтэй холбоотой мэдээлэл дутуу бүрдүүлэн 41000.0 мянган төгрөгийн зээл олгож байгаа зөрчил байна. Иймээс олгож буй зээлийг зээлийн мэдээллийн санд оруулж, нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх шаардлагатай байна.
- 1.2. Эрсдэл: Сангийн хөрөнгийг эргэц удаашрах, эргэн төлөгдөхгүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4. "үнэн зөв байх" зарчим, 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах, зээлдэгч нарын мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

##### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Жаргалант сумын хэмжээнд нийтийг хамарсан ажилд ажилгүй иргэдийг хамруулан түр ажлын байранд ХХҮГ-аас ирүүлсэн жагсаалтад байгаа хүмүүс дээр нэмж сумын 12 багуудаас ажилгүй хүмүүсийг бүртгэхдээ Хот тохижилтын нягтлан бодогч, нярав нар нь өөрийн хамаарал бүхий этгээдийг бүртгэсэн боловч тухайн хүмүүс нь ажиллаагүй, ААНБ-д ажилладаг хүмүүс ажиллуулж цалин олгодог гэсэн мэдээлэл иргэдийг бухимдуулж байгаа нь тухайн НХА-ын явцын хяналт хэрэгжүүлээгүй, ажилласан ажиллаагүйг нотлох баримтгүй байна.

2.2. Эрсдэл: Ажлын үр дүн буурах, хариуцлага алдагдах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 3.5-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ", 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

### **3.Зардлын данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт: Шатахуун түгээх байгууллагатай хамтран ажиллах гэрээнд зааснаар урамшуулалд олгосон 197.5 мянган төгрөгийн шатахууныг орлогод аваагүй, 2020 онд ХЭДС-аас 11993.3 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан боловч жолоочийн тооцоог бүрэн бодоогүй, зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.

3.2. Эрсдэл: Жолоочийн тооцоо бүрэн бодоогүй байх, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилт", 5.1.4-д "үнэн зөв байх" гэсэн заалтуудыг мөрдөн төсвийг үр ашигтай зарцуулах, санхүүгийн тайланг үнэн зөв гаргах талаар анхааран ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

### **4.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт: Гөү Окей ХХК-тай гэрээ байгуулан "санхүүгийн дэмжлэгийн модуль боловсруулах" зорилгоор 6500.0 мянган төгрөгөөр программ хангамжид нэмэлт сайжруулсан, Эв эе эвийн хүч худалдааны төвд "Залуучуудын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах цэг" байгуулахад 2350.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 260.0 мянган төгрөгийн БҮТЭЗ худалдан авч данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан.

3.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө эзэнгүйдэх,

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагаа заавал бүртгэнэ" гэсний дагуу хөрөнгөө данс бүртгэлд тусган ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

### **5.Сургалтын зардалтай холбоотой асуудал**

5.1. Илрүүлэлт: ХЭДС-ийн үйл ажиллагаатай холбоотой албан хаагчдад сургалт зохион байгуулахдаа ажилчдад бал, дэвтэр олгох, 1,2 дугаар хоол өгөх зэрэгт 7164.5 мянган төгрөгийг зарцуулсан нь сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулаагүй дутагдал байна.

5.2. Эрсдэл: Сангийн хөрөнгийг үр өгөөж буурах,

5.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсний дагуу сангийн хөрөнгийг үр пүнтэй зарцуулах талаар анхааран ажиллах

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: <b>2021</b>	Аудитын нэр: <b>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>ХОА-2021/3/СТА-ЗГТС</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан</b>	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын үлдэгдэлд тооллого хийж үлдэгдлийг дутуу тусгасан, тайлант оны үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	1460.0	Залруулга хийх	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга, нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Т.Сайнбаяр
2	Гөү Окей ХХК-тай гэрээ байгуулан "санхүүгийн дэмжлэгийн модуль боловсруулах" зорилгоор программ хангамжид нэмэлт сайжруулсан, Эв эе эвийн хүч худалдааны төвд "Залуучуудын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах цэг" байгуулахад үндсэн хөрөнгө, БҮТЭЗ худалдан авч данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан.	9110.0	Зөвлөмж өгөх		
3	Шатахуун түгээх байгууллагатай хамтран ажиллах гэрээнд зааснаар урамшуулалд олгосон шатахууныг орлогод аваагүй, 2020 онд ХЭДС-аас шатахууны зардалд зарцуулсан, жолоочийн тооцоог бүрэн бодоогүй, зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.	12190.8	Зөвлөмж өгөх		
4	Төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаа зээлдэгчид нь Монгол банкны мэдээллийн санд оруулаагүйгээс сумдын СХС болон бусад хэлбэрээр зээл авсан хүмүүс давхардуулан зээл олгодог	41000.0	Зөвлөмж өгөх		
5	ХЭДС-ийн үйл ажиллагаатай холбоотой албан хаагчдад сургалт зохион байгуулахдаа ажилчдад бал, дэвтэр болон 1,2 дугаар хоол өгөх зэрэгт зарцуулж байгаа нь сангийн хөрөнгийг сангийн хөрөнгийг үр өгөөжийг бууруулж байна.	7164.5	Зөвлөмж өгөх		
6	Жаргалант сумын хэмжээнд нийтийг хамарсан ажилд ажилгүй иргэдийг хамруулан түр ажлын байранд ХХҮГ-аас ирүүлсэн жагсаалтад байгаа хүмүүс дээр нэмж сумын 12 багуудаас ажилгүй хүмүүсийг бүртгэхдээ Хот тохижилтын нягтлан бодогч, нярав нар нь өөрийн хамаарал бүхий этгээдийг бүртгэсэн боловч тухайн хүмүүс нь ажиллаагүй, ААНБ-д ажилладаг хүмүүс ажиллуулж цалин олгодог гэсэн мэдээлэл иргэдийг бухимдуулж байгаа нь тухайн НХА-ын явцын хяналт хэрэгжүүлээгүй, ажилласан ажиллаагүйг нотлох баримтгүй байна.	-	Зөвлөмж өгөх		
<b>ДҮН</b>		70925.3			

## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР